

1	<p>ОХУ-д FIDIC-ийн гишүүн (https://fidic.org/membership/membership_associations) нь Барилгын тоног төхөөрөмжийн зөвлөхүүдийн үндэсний холбоо (NACEC) https://naces.ru/ юм. NACEC гэрчилгээ нь FIDIC баталгаажуулалт байж чадах уу?</p>	<p>NACEC гэрчилгээ нь FIDIC баталгаажуулалт байж чадахгүй. FIDIC гэрээгээр мэргэшсэнийг олон улсын инженерүүдийн холбоо FIDIC-ээс батламжилсан сургалтын байгууллагуудаас олгодог болно.</p>
2	<p>ФИДИК ийн гэрээгээр мэргэшсэн гэдгийг яаж тодорхойлох вэ?</p>	<p>FIDIC гэрээгээр мэргэшсэнийг олон улсын инженерүүдийн холбоо FIDIC-ээс батламжилсан сургалтын байгууллагуудаас олгодог болно.</p>
3	<p>Тендерийн баримт бичигд зааснаар шаардсан инженер техникийн ажилчдын 50%-иас доошгүй хувь нь FIDIC-ийн гэрээгээр мэргэшсэн ажилчид байхыг шаардсан байна. FIDIC-ийн шаардлагын талаар дэлгэрүүлж өгнө үү. Бидний хуримтлуулсан туршлагаар FIDIC-ийн туршлагатай хүн Менежментийн түвшинд цөөн тоогоор байхад хүрэлцээтэй байдаг. Шаардсан инженер техникийн ажилчид гэдгийг Тендерийн баримт бичгийн ШТЗ 19.1-т заасан 12 албан тушаалтныг хэлж байгаа юу? FIDIC-ийн ямар шалгуур гэдгийг тодорхойлж өгнө үү.</p>	<p>FIDIC гэрээгээр мэргэшсэнийг олон улсын инженерүүдийн холбоо FIDIC-ээс батламжилсан сургалтын байгууллагуудаас олгодог болно. Шаардсан инженер техникийн ажилчид гэдгийг Тендерийн баримт бичгийн ШТЗ 19.1-т заасан 12 албан тушаалтнаар ойлгоно.</p>
4	<p>Тендерийн баримт бичигт зааснаар шаардсан инженер техникийн ажилчдын 5-аас багагүй нь PMP сертификаттай байна гэж шаардсан байна. Тус сертификатыг илүү дэлгэрэнгүй тайлбарлана уу. Шаардсан инженер техникийн ажилчид гэдгийг Тендерийн баримт бичгийн ШТЗ 19.1-т заасан 12 албан тушаалтныг хэлж байгаа юу?</p>	<p>PMP сертификаттай холбоотой мэдээллийг https://www.pmi.org/certifications/project-management-pmp цахим хуудсаар орж харна уу Шаардсан инженер техникийн ажилчид гэдгийг Тендерийн баримт бичгийн ШТЗ 19.1-т заасан 12 албан тушаалтнаар ойлгоно.</p>
5	<p>Тендерийн 2-р үе шатад шалгарсан буюу зөвлөх үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгч, түншлэлийн аливаа гишүүн нь ирээдүйд зарлагдах Метроны тендерийн EPC гэрээ эсхүл барилга угсралтын ажил дээр зарлагдсан тендерт өрсөлдөх, оролцох боломжтой юу?</p>	<p>Тендер шалгаруулалтын 2-р үе шатанд оролцоод гэрээ байгуулах эрх авсан, гэрээ байгуулсан зөвлөх үйлчилгээний үндсэн гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгч, түншлэлийн гишүүн нь цаашид зарлагдах Метроны тендер шалгаруулалтын EPC гэрээ эсхүл барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцох боломжгүй.</p>

6	Оролцогч хүний нөөц нь албан үүргээс хамаарахгүйгээр Захиалагч шаардсан 12 хүний 50%-иас доошгүй хувь болох 6 хүн нь FIDIC-ээр мэргэшсэн ажилчид байх шаардлагатай юу?	Тийм. 6 ба түүнээс дээш гэж ойлгож болно.
7	<p>Хэрэв оролцогч хүний нөөцийн FIDIC хангах нөхцөл нь “FIDIC сертификат гэрчилгээ” гэвэл дараах асуудал гарна.</p> <ul style="list-style-type: none"> - Бүх улсууд дотооддоо “FIDIC сертификат гэрчилгээ”-г олгох боломжгүй байгаа. - “FIDIC сертификат гэрчилгээ” нь заавал байх нөхцөлтэй гэвэл тухайн улс орондоо авч чадахгүй улс орнуудаас оролцож байгаа компани нь өөрийн улсдаа авах боломжтой улс орнуудтай харьцуулахад эрх тэгш бус бөгөөд, - Цаашлаад “татгалзах” нөхцөл болох ба саналыг өгөхөө урьдчилан цуцлаж ч болзошгүй оролцогч нар гарч болно. - Захиалагч (НЗДТГ)-ийн зүгээс ч олон оролцогч оролцож мөн өрсөлдөөнтэй үнэ болон чанартай саналыг авахад хүндрэлтэй болно гэж үзэж байна. 	FIDIC гэрээгээр мэргэшсэнийг олон улсын инженерүүдийн холбоо FIDIC-ээс батламжилсан сургалтын байгууллагуудаас олгодог болно.
8	Улмаар оролцогч хүний нөөц нь “FIDIC сургалтад суусан батламж”-ийг явуулахад нөхцөлийг хангасан гэж хүлээн зөвшөөрч тодорхой, зарим нэг оролцогч санал гомдол гаргахаас урьдчилан сэргийлж, оролцогч оролцохоо цуцлахгүй байх талаас нь зохицуулалт хийж өгнө үү.	
9	Тендерт 3 болон түүнээс дээш байгууллага түншлэл байгуулан оролцох боломжтой юу?	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг Түншлэлийн гишүүн бүрийн гүйцэтгэх үүрэг тендерийн үнийн 20 хувиас дээш байна.</p> <p>Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ.</p>

10	Тендерт оролцогч өөрийн санхүүгийн чадавхийг толгой компанийн санхүүгийн чадавхиар (толгой компаниар баталгаа гаргуулах замаар) баталгаажуулж болох уу?	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
12	Гадаадын банкнаас гаргасан тендерийн банкны баталгааг яаж баталгаажуулах вэ?	Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиолдолд Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралт “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 4 дэх хэсгийн дагуу гаргаж ирүүлнэ.
13	Урьдчилгаа төлбөрийг гэрээнд тусгаж болох уу? ТШЗ 2.1.-д заагдсан 2024 оны санхүүжилт нь ямар гүйцэтгэгдсэн ажлууд ба үйлчилгээнүүдийг санхүүжүүлэх зориулалттай вэ ?	Урьдчилгаа төлбөрийг гэрээний хэлэлцээрийн шатанд тохиролцоно. Гүйцэтгэх ажлын талаар батлагдсан ажлын даалгавраас танилцана уу.
14	"Шаардлагатай" гэсэн тэмдэглэгээтэй заалтуудын аль нэгийг биелүүлээгүй нь тендерээс татгалзах хангалттай үндэслэл болох уу?	Тийм.
15	Бид дэлхий даяар 6 метроны төслүүдэд ижил төстэй үйлчилгээг гүйцэтгэж байгаа тул мэргэжилтнүүдийн хувьд FIDIC-ийн шаардлагыг хасахыг хүсч байна. Энэ заалт нь зөв ажилд тохирох хүнийг сонгохыг хязгаарладаг, жишээлбэл, FIDIC гэрчилгээ байхгүйн улмаас маш сайн засвар үйлчилгээний хүний нөөцийг орох боломжыг хязгаарлаж болох юм.	Шаардсан инженер техникийн ажилжид гэдгийг Тендерийн баримт бичгийн ШТЗ 19.1-т заасан 12 албан тушаалтны 50 хувиар тооцно. Бусад ИТА-нд дээрх шаардлагыг тавиагүй.
16	Тендерийн баталгааны маягтыг хуваалцана уу	Хавсралтаар оруулав.
17	Тендерийн баталгааг хэний хүсэлтээр хаана төлөгдөх нөхцөлтэйгөөр гаргуулах вэ	Хавсралтаар оруулсан тендерийн баталгааны маягтыг харна уу.

18	ТШЗ 24.1-т заасан Гадаадын этгээд гадаад улсын банкнаас баталгаа гаргуулах тохиололд Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралт “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-ын 4 дэх хэсгийн дагуу гаргаж ирүүлнэ гэсэн тус тушаалын хавсралтыг англиар хүргүүлж өгнө үү.	Захиалагчийн зүгээс албан ёсны орчуулга хүргүүлэх боломжгүй.
19	РМС нь төслийн хэрэгжилтийн төлөвлөгөөг санал болгох бөгөөд үүнд ажлын багцыг багтаасан болно гэж бид ойлгож байна. Ихэвчлэн ЕРС гэрээг (i) Барилгын ажил, (ii) Системийн ажил, (iii) Хөдлөх бүрэлдэхүүн гэсэн гурван ангилалд хуваадаг.	ЕРС гэрээний хүрээнд хийгдэх ажлыг ажлын даалгавраар тодорхойлно.
20	Дээр дурдсанчлан ангилал тус бүрээр гурван тусдаа ЕРС гүйцэтгэгч байх бөгөөд ажлын даалгаварт дурдсан 6 сарын хугацаа нь худалдан авалтыг дуусгахад хангалттай гэдгийг тодруулна уу.	Техникийн тодорхойлолт (Үйлчилгээний даалгавар)-ын В(б) Төслийн үе шат-д “Төслийн менежментийн зөвлөх нь суурь судалгааны эскиз зураг боловсруулах үе шатанд богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажиллах зорилт тавин ажиллах зорилтыг дэвшүүлэн төслийн үе шатыг эцэслэн тогтооно.” гэж заасан тул тус хугацаа талууд харилцан тохиролцож тогтооно.
21	Холбогдох ижил төстэй ажлын туршлагатай ОУ-ын компанийн Монгол дах салбар оролцож байгаа тохиолдолд тус компанийг туршлагатай гэж тооцох уу.	Монгол улс дахь салбар нь өөрсдийнхөө хийж байсан туршлагын талаарх нотлох баримтыг ирүүлэхийг анхаарна уу.
22	2-р шатанд ороогүй компанитай 2-р шатанд орсон оролцогч түншлэл болоод оролцож болох уу.	Болохгүй. Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ. (Өмнөх тодруулгын хариуг харна уу.)
23	Бид бүх оролцогчдыг албан тушаал бүрийн хүн сар гэх мэтчилэн нийтлэг үзүүлэлтүүдээр үнэ тогтоох боломжийг	ТЖББ-ийн “Гэрээ баталгаажуулах маягт”-ын Хавсралт 3-т “Гэрээний үнийн задаргаа, төлбөрийн нөхцөл ба журам”

	олгохыг хүсч байна. Мөн олон улсын болон дотоодын хүний нөөцийн нийт хүн сарыг гэрээний шатанд нарийн тодорхойлох боломжыг нээж өгөхийг хүсч байна.	хүснэгтийг оролцогчдоос бөглөж ирүүлнэ. Энэхүү хүснэгтэд заасан мэдээллийг хэлэлцээрийн явцад талууд харилцан тохиролцож тодорхойлно.
24	Төлбөрийн валютыг монгол мөнгөн тэмдэгт гэж дурдсан. Олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц тендер, гадаадын фирмүүдийн оролцоо, валютын ханшийн хэлбэлзэл зэргийг харгалзан зөвлөхөд төлөх төлбөрийг дараахь байдлаар хийхийг хүсч байна:	Тендерийн үнийн саналыг гадаад орны валютаар ирүүлж болох бөгөөд тендерийн шалгаруулалтын үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27.2.2 дахь заалт, 28.7 дахь хэсгийн дагуу гадаад валютуаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк (Монгол банк)-ны албан ханшаар тооцож хөрвүүлнэ. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийнэ. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.
25	Дотоодын хүний нөөцийн албан тушаал, шинжээч, зардлын төлбөрийг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх.	
26	Олон улсын шинжээчид болон зардлын хувьд төлбөрийг олон улсын бүрэн хөрвөх валютаар (ам. доллар/Евро/йен/Британ фунт) хийх.	
27	Мөн тендерт оролцогчид төлбөрийн нөхцлөө санал болгохын оронд захиалагч нь тухайн сарын бүх албан тушаал, зардлын сарын хувь хэмжээг харгалзан холбогдох татвар, хураамжийн хамт зөвлөхөд сар бүр төлж байхыг хүсч байна.	
28	Зөвлөхөд гүйцэтгэсэн ажлын төлбөрийг төлөхөд, түншлэл бол яаж төлөх болохыг тодруулж өгнө үү; Төлбөрийг зөвхөн тэргүүлэгч гишүүнд бус, түншилсэн бие даасан гишүүдэд шууд хийх уу.	
29	Тус тендер нь техникийн талын чанарыг илүү чухалчлах ёстой тул тендерийн үнэлгээг хамгийн бага үнийн аргаар бус QCBS буюу техникийн санал 80%, үнийн санал 20%-ийн харьцааг баримталж үнэлж өгнө үү.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалтын дагуу “Харьцуулах үнэ” гэсэн үндсэн шалгуурыг баримтлана. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, энэ хуулийн 11.4.2-т зааснаар үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу тооцсон үнийг тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.

30	Олон нийтийн хариуцлагын даатгал гэдэг нь Гуравдагч этгээдийн даатгал гэдэгтэй адилтгаж үзэж болох уу. Юуг хамарч байх ёстой вэ?	Энэ даатгал нь гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилготой. Өөрөөр хэлбэл ТМЗ-ийн бусдад учруулсан хохирлыг даатгалаар нөхөн төлүүлэх зорилготой.
31	Шалгарсан тохиолдолд МОНгол Улсад өөрийн төлөөлгчийн газраа байгуулж шаардлагатай тусгай зөвшөөрөл болон ажилчдынхаа визийг авах шаардлагатай юу?	Шалгарсан тохиолдолд Монгол Улсад өөрийн төлөөлөгчийн газраа байгуулж шаардлагатай тусгай зөвшөөрөл болон ажилчдынхаа визийг авах шаардлагатай. Техникийн тодорхойлолтын “Захиалагчаас үзүүлэх дэмжлэг” хэсгийг үзнэ үү.
32	Зөвлөхөд төлбөр хийхдээ орлогын албан татвар, суутгалын албан татвар, НӨАТ-ын ямар төрлийн хувь хэмжээг Зөвлөхөд ноогдуулах вэ?	<p>Орлогын албан татвар (IT): Орлогын татварын хувь хэмжээ нь зөвлөхийн харьяагдах тухайн улсаас хамаарч өөр байж болно. Мөн Зөвлөхүүдийн орлогын албан татварын хувь хэмжээ нь Монгол Улсад тэдний оршин суугаа статус (оршин суугч, оршин суугч бус) болон орлогын шинж чанараас хамаарч өөр хувь хэмжээтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> • Оршин суугчдын хувьд Монгол Улсад орлогын албан татварын хувь хэмжээ 10-25 хувь байна. • Оршин суугч бус иргэд Монголоос олж байгаа орлогын эх үүсвэрт 20 хувийн татвар ногдуулж болно. <p>Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний орлогод яг тохирсон хувь хэмжээг тогтоохын тулд Монгол Улсын Татварын Ерөнхий хууль, болон холбогдох татварын хуулиудын заалтуудыг нарийн судалж, хэрэгжүүлэх нь чухал юм.</p> <p>Суутган татвар төлөгч (WHT): Оршин суугч бус зөвлөхүүдэд төлбөр хийхдээ суутгалын татварыг ихэвчлэн эх үүсвэрээс нь суутган авдаг. Монголд оршин суугч бус иргэдийн үзүүлж буй үйлчилгээний WHT-ийн хувь хэмжээ харилцан адилгүй байж болно. Тодорхой хувь хэмжээг тогтоохын тулд Монгол Улсын давхар татварын гэрээнд (ДТТ) заасан байдлыг харгалзан албан татварыг суутган тооцож төлбөрийг хүлээн авна.</p>

		<p>Монгол Улс нь зарим нэг улс оруудтай ДТТ-тэй байдаг ба хуулийн хэрэгжилтийн хүрээнд WHT-ийн хэмжээг бууруулж эсвэл чөлөөлдөг. Эдгээр гэрээ нь давхар татвараас урьдчилан сэргийлэх, хил дамнасан худалдааг дэмжих зорилготой.</p> <p>Жишээлбэл, хэрэв Монгол Улс болон зөвлөхийн эх орны хооронд ДТТ байгаа бол WHT-ийн хувь хэмжээ стандарт хэмжээнээс бага байж болно.</p> <p>Нэмэгдсэн өртгийн албан татвар (VAT): <u>НӨАТ</u> гэдэг нь үйлдвэрлэл, түгээлтийн үе шат бүрт нэмэгдсэн өртгөөс ногдуулдаг хэрэглээний татвар юм. Монгол улсад <u>НӨАТ</u>-ын хувь хэмжээ 10 хувь байдаг. Гэсэн хэдий ч, зарим үйлчилгээг чөлөөлөх эсвэл хөнгөлөлттэй үнээр тооцох боломжтой. Иймд НӨАТ-ийн хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар <u>гарын авлагыг</u> дэлгэрэнгүйгээр судлана уу</p> <p>Төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ нь тодорхой чөлөөлөлт, заалт байхгүй бол стандарт НӨАТ-ын хувь хэмжээ 10% байна.</p> <p>Захиалагчийн хяналттай холбоотой зардлыг үнэлгээний хороо нэмж хариулт өгнө</p>
33	<p>Хэрэв PMS хүний нөөцийн зарим албан тушаалтнаа сэлгэн солих хүсэлт гаргасан тохиолдолд цалингийн хэмжээг бууруулахгүй эсхүл торгууль ногдуулахгүй гэж ойлгож байна. Бататгана уу.</p>	<p>Төлбөрийн нөхцөлийг хэлэлцээрийн шатанд шийдвэрлэнэ. Урьдчилсан байдлаар Lump sum зарчмыг баримтлах саналтай бөгөөд төслийн зарим шатанд Үнийн дээд хязгаар бүхий Time based зарчмаар явах зарчмыг баримтална. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.</p> <p>Хэрэв time based зарчмаар явах тохиолдолд ажиллах хүчний шаардлага хангасан ижил түвшний боловсон хүчнийг шаардана.</p>
34	<p>Олон улсын болон үндэсний мэргэжилтнүүдийн нийт хүн сарыг зааж өгөх.</p>	<p>ТЖББ-ийн “Гэрээ баталгаажуулах маягт”-ын Хавсралт 3-т “Гэрээний үнийн задаргаа, төлбөрийн нөхцөл ба журам” хүснэгтийг оролцогчдоос бөглөж ирүүлнэ. Энэхүү хүснэгтэд</p>

		заасан мэдээллийг хэлэлцээрийн явцад талууд харилцан тохиролцож тодорхойлно.
35	Гэрээний хугацаанд олон улсын шинжээчдийн хувьд жил бүр 3-аас доошгүй хувийн өсөлттэй байх ёстой.	ТЖББ-ийн Өгөгдлийн хүснэгтийн “ТШЗ 21.4-т” Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахаар заасан бөгөөд тохируулгын тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “11.11-т Захиалагч гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчээс үл хамаарах шалтгаанаар бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гэрээний үнийг тохируулах бол тохируулга хийх нөхцөл, аргачлалыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэснийг анхаарах нь зүйтэй.
36	Гэрээний хугацаанд жил бүр Монгол Улсад зонхилох инфляцийн түвшинтэй тэнцэх хэмжээний өсөлтийг үндэсний мэргэжилтнүүд хийх ёстой.	
37	Зөвлөхийн шууд хяналтаас гадуур ямар нэг шалтгаанаар ажлын явц удааширсан тохиолдолд гэрээний нөхцөлд үлдсэн хүн сарыг ашиглах, ажлын гүйцэтгэлийг хангахын тулд сүүлийн тооцооны хувь хэмжээг үндэслэн ажлын хөлсийг нэмэгдүүлэх заалтыг тусгаж өгөх .	FIDIC White Book 2017 гэрээний 4.4 дэх хэсгийн заалтыг үзнэ үү.
38	Ажлын 1-р шатанд ТЭЗҮ-ийг шинэчлэхийн тулд хийх ажлын тоо хэмжээг заагаагүй тул суурь судалгаа, зураг төсөл боловсруулах зэрэг үйл ажиллагаанд гарсан холбогдох бүх зардлыг (холбогдох татвар, хураамжийг оруулаад) зөвлөх ажлаа хүлээлгэсний дараагаар нэхэмжлэхээр тусгаж өгөхийг хүсч байна.	ТЖББ-ийн “Гэрээ баталгаажуулах маягт”-ын Хавсралт 3, Хүснэгт 3.6 Судалгаа, ажлын зардал, Хавсралт 5 Хүлээлгэн өгөх баримт бичгийн жагсаалт зэргийг оролцогчоос санал болгож ирүүлэх ба талууд хэлэлцээрийн шатанд эцэслэн төлбөрийн нөхцөлийг тохирно.
39	Бид ажиллах хүчний жагсаалтыг апостилээр баталгаажуулах болон консулын баталгааг хасахыг хүсч байна. Оронд нь тендерт гарын үсэг зурсан эрх бүхий этгээд өөрөө баталгаажуулж буй болохыг хүлээн зөвшөөрөхийг хүсч байна.	Тендерийн баримт бичигт Консулын баталгаа эсхүл Апостиль баталгаа шаардсан хэсгүүдэд тус баталгаануудыг шаардана.
40	Энэ тендер нь Олон улсын өрсөлдөөнт тендер тул англи хэл дээр санал ирүүлэхийг зөвшөөрөхийг та бүхнээс хүсэж байна.	Тендерийн хэл нь Монгол хэл байна.

41	Тендер нь маш өрсөлдөөнтэй, монгол хэл дээр орчуулга хийх шаардлагатай байгаа тул санал ирүүлэх эцсийн хугацааг бүх тодруулга өгсөн өдрөөс хойш 8 долоо хоногоор сунгахыг бид хүсч байна.	Захиалагчийн зүгээс оролцогчдын гаргасан хүсэлт, шаардлагыг үндэслэн тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацааг сунгасан.
42	Бидний туршлага нь ихэнхдээ түншлэлийн гишүүн эсвэл дизайны нэгж байдлаар байна. Бид гэрээгээ шууд захиалагчтай байгуулдаг ба гэрээнд захиалагч, манай тал болон түншлэлийн гол төлөөлөгч (эсвэл гэрээний ерөнхий гүйцэтгэгч) гэсэн талууд гарын үсэг зурж тамга дардаг. Ийм тохиолдолд манай туршлагыг тооцож үзэх үү?	Үндсэн болон түншлэлээр гүйцэтгэсэн ажлын туршлагыг тооцон үзнэ.
43	Түншлэлийн гол төлөөлөгч нь чадавхын болон туршлагын шаардлагын 40%-аас дээш хувийг хангасан байх шаардлагатай байна. Энэ тохиолдолд бид туслан гүйцэтгэгчээр оролцсон туршлагаа ашиглаж болох уу?	
44	Тодруулгын хариултын 10-р хариултанд "Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. ..." гэж заажээ. Үүнийг эхний шатанд оролцоогүй аж ахуйн нэгж туслан гүйцэтгэгчээр мөн адил 2-р шатанд оролцох боломжгүй гэж ойлгож болох уу?	Эхний шатанд оролцсон 20 оролцогч өөр хоорондоо түншлэл, туслан гүйцэтгэгчээр хэлбэрээр оролцож болно. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсгийн дагуу Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нэгдүгээр үе шатанд оролцсон этгээд тендер ирүүлнэ. Харин туслан гүйцэтгэгчээр эхний шатанд оролцоогүй оролцогчийг оруулцуулж болно.
45	Маргааныг шийдвэрлэх газраар талуудын эрх ашгийг тэгш хангахуйц ОУ ын Арбитрийн байгууллагыг сонгох.	ТЖББ-ийн VI бүлэг "Гэрээний нөхцөл" хэсэгт олон улсын тендер шалгаруулалтыг харгалзан Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг Зөвлөх үйлчилгээний гэрээ (White book, 2017)-ний нөхцөлийг хэрэглэхээр заасан. Тус бүлгийн Гэрээний тусгай нөхцөлийн В хэсгийн 10-т "Маргаан шийдвэрлэх, арбитр: маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхэд шилжүүлж, эцэслэн шийдвэрлүүлнэ гэж заасан. ТЖББ-ийн ТШЗ 38.2-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлд нэмэлт

		өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл саналаа албан бичгээр тендерийн материалд ирүүлж болно” гэж заасан тул саналаа тендерийн материалд ирүүлнэ.
46	Гэрээний валютийг ОУ худалдааны байгууллагын үндсэн төлбөрийн хэрэгсэл болох Америк Доллараар хийх боломжтой эсэх.	Тендерийн үнийн саналыг гадаад орны валютаар ирүүлж болох тендерийн шалгаруулалтын үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27.2.2 дахь заалт, 28.7 дахь хэсгийн дагуу гадаад валютаар ирүүлсэн тендерийн үнийг тендер шалгаруулалт зарласан өдрийн Төв банк (Монгол банк)-ны албан ханшаар тооцож хөрвүүлнэ. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2 дахь заалтуудын төгрөгөөр хийнэ. Шалгарсан тохиолдолд гэрээний зарчмыг хэлэлцээрийн шатанд эцэслэн тохиролцож болно.